



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/140

Мандалговь

Төсөл санхүүжүүлэх тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 58 дугаар зүйлийн 58.2.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 07 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.4, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3.3.1 дэх заалтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Өсвөрийн шигшээ багийг тоглолтын хувцсаар хангах" төслийн төсвийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах 6.246.000 /зургаан сая хоёр зуун дөчин зургаан мянган/ төгрөгийг төсөл, хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлж, төслийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, Санхүү, төрийн сангийн хэлтэс /А.Ганбат/-т тус тус даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

020000400

Аймгийн Засаг даргын 2017 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 11/202 тоот захирамжийн хавсралт



Төсвийн тооцоо

№	Зардлын утга	Хүйс	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Волейболын хослол	эм	12	45000	540000
2	Дан футволк	эм	12	25000	300000
3	Волейболын хослол	эр	12	48000	576000
4	Дан футволк	эр	12	28000	336000
5	Сагсан бөмбөгийн хослол	эр	12	55000	660000
6	Дан футволк	эр	12	30000	360000
7	Сагсан бөмбөгийн хослол	эм	12	55000	660000
8	Дан футволк	эм	12	30000	360000
9	Хөл бөмбөгийн хослол	эр	18	45000	810000
10	Дан футволк	эр	18	28000	504000
11	Аймгийн ЗДТГ-ын волейболын баг тамирчдын хослол	эм	8	45000	360000
12	Аймгийн ЗДТГ-ын волейболын баг тамирчдын хослол	эр	10	48000	480000
13	Аймгийн лого		150	2000	300000
	БҮГД ДҮН				6.246.000